



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 328

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Засгийн газрын 10 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 45,676,171.00 (дөчин таван сая зургаан зуун далан зургаан мянга нэг зуун далан нэгэн) төгрөгийн балансын үнэ, 5,873,955.62 (таван сая найман зуун далан гурван мянга есөн зуун тавин төгрөг жаран хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Сангийн яамны хүзүүвчийн барилгыг буулгаж, чөлөөлсөн газрыг “Сангийн яамны өртгөтгөл мэдээллийн нэгдсэн дата төв”-ийн албан конторын зориулалтаар нь ашиглах, газрыг нөхөн сэргээх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.Н.Доржсүрэн

Д.НАРАНГЭРЭЛ

132001387



Төрийн ёмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны
07 дугаар сарын 08-ний өдрийн
388 дугаар тогтоолын хавсралт

**Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах
хөрөнгийн жагсаалт**

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	хүзүүвч	2011	м2	29.92	45,676,171.00	5,873,955.62	39,802,215.38
	ХӨРӨНГИЙН ДҮН				45,676,171.00 (дөчин таван сая зургаан зуун далан зургаан мянга нэг зуун далан нэгэн)	5,873,955.62 (таван сая найман зуун далан турван мянга есөн зуун таван төгрөг жаран хоёр мөнгө)	39,802,215.38 (гучин есөн сая найман зуун хоёр мянга хоёр зуун арван таван төгрөг гучин найман мөнгө)